



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугвар 1/185

Ховд

Г Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Казак үндэсний "Наурыз" баярыг тохиолдуулан эрхэлсэн ажил үйлсээрээ хамт олноо манлайлан ажиллаж буй Ховд сумын Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Т.Далелхан, Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан Т.Күлсагари, математик, мэдээлэл зүйн багш Х.Бахытгүл, Дунд-Ус өртөөний техникч Н.Бахытгүл нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Т.Далелхан, Т.Күлсагари, Х.Бахытгүл, Н.Бахытгүл нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Ховд сумын Засаг дарга, Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 00052
DZax-A/185 Da